



“ПИПЛ ИН НИЙД” ОЛОН УЛСЫН ТББ-ЫН
МОНГОЛ УЛСАД БАРИМТЛАХ СТРАТЕГИ
2022–2026 он

Агуулга

- | | |
|---|----|
| 1. Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал | 3 |
| 2. Пипл-ин-Нийдийн чиг үүрэг, Монгол дахь үйл ажиллагаа | 6 |
| 3. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд | 8 |
| 4. Хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй төслүүд | 13 |
| 5. Хавсралт | 15 |



1. Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал

Байгалийн баялаг өдрөөс өдөрт шавхагдан, уур амьсгал өөрчлөгдөж байгаа нь урт хугацааны түрш тулгамдаж буй томоохон асуудлуудын нэг билээ. Хүний хүчин зүйлээс улбаатай уур амьсгалын өөрчлөлт болон хүн төрөлхтөнөөс хамааралтай бусад үйл ажиллагаа **гамшгийн эрсдэлийг гааруулж, байгаль орчныг сүйтгэхэд хүчтэй нөлөө үзүүлсээр байна.** Сүүлийн 60 жилд асар хурдтай явагдаж буй дэлхийн дулаарал Монгол Улст хамгийн ихээр нөлөөлж байна. **Агаарын бохирдол улам даамжирч, түүнээс үүдэлтэй өвчлөл газар аван, үер, ган гачиг зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд ихээр нэрвэгдэх боллоо.**

Хурдацтай явагдаж буй хотжилт, чулуун нүүрс, шахмал түлшний хэрэглээ, уул уурхайн аж үйлдвэржилт, бэлчээрийн нөхөн сэргээлт хангалтгүй байгаагийн улмаас агаарын бохирдол нэмэгдэж (*Улаанбаатар хот өвөлдөө агаарын чанарын үзүүлэлтээр хамгийн мууд тооцогдох хотуудын нэг болсон*), **усны бохирдол ихсэн** (*зарим бүс нутагт нийт ус таталт сэргээгдэх усны хангамжаас жилд 50-аиаас доошгүй хувиар давж*), **бэлчээр доройтож байна** (*өвстэй газрын 90% нь тодорхой хэмжээгээр цөлжсөн*). Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр эдгээр асуудал улам хурцадсаар байна. Газар авахуулалгүй барьж, өмнөх байдалд нь эргэн оруулж эс чадваас эдгээр асуудал дунд болоод урт хугацаанд хүн амын эрүүл мэнд, эдийн засгийн өсөлтөд чөдөр тушаа болох магадлалтай.

Тус улсад тулгараад байгаа **байгаль орчинтой холбоотой энэхүү сэтгэл зовоосон асуудлыг шийдэхэд** чиглэсэн дүрэм журам боловсруулах, институт бий болгох чиглэлээр хүчин чармайлт гаргаж байна. Гэсэн хэдий ч нэг талаас олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, нөгөө талаас алсыг харсан, оновчтой шийдвэр гаргах хэрэгцээ оршоор. Олон нийт хийгээд бодлого боловсруулагчид эдгээр ноцтой асуудлыг ч шийдвэрлэж хүчрэхгүй, нөхцөл байдал улам дордохоос сэргийлэх бодлого дутагдаж,

үйл ажиллагаа нь хангалттай үр дүн авчрахгүй байгаа нь энэ талын мэдээлэл хомс байгааг илтгэнэ.

Коронавирусын цар тахал, түүнээс үүдсэн худалдааны саатал багасаж, 2023 оноос өсөх төлөвтэй байсан **Монгол Улсын эдийн засаг** инфляц, худалдааны байнгын саатал, болзол нь улам чангарч буй гадаад санхүүжилт, геополитикийн ээдрээтэй нөхцөл байдлын нөлөөнд өртөх магадлалтай байна. Монгол Улсын эдийн засгийн 2021 оны 1.4%-ийн өсөлт 2022 онд 2.3%-иар тэлж, улмаар дотоодын эрэлт хэрэгцээ, хөрөнгө оруулалт болон аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын сэргэлтээр 2023 онд 5.6% хүртэл өсөх таамаглалыг Азийн Хөгжлийн Банк гаргасан ба бодит өсөлт 7.0% байв¹.

Оросын Холбооны Улс Украин руу халдсан нь төлбөрийн тэнцэл, төсвийн байдал, инфляци, бизнесийн үйл ажиллагаанд тулгарах дарамтыг нэмэгдүүлснээр Монголын эдийн засагт учирч болох эрсдэл ихсэв. Азийн Хөгжлийн Банк Монгол Улсыг эдийн засгийн тогтвортой байдал, өрсөлдөх чадвараа бэхжүүлэхийн төлөөх бүтцийн шинэчлэлийг урагшлуулах хүчин чармайлтаа гүнзгийрүүлэхийн сацуу макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, гадаад, дотоодын санхүүжилтийн хэрэгцээг хангахын тулд эдийн засгийн циклийн нөлөөллийг сааруулах багц бодлого боловсруулахад онцгой анхаарах нь зүйтэй гэж үзэж байна².

2022-2023 оны өсөлт нь БНХАУ-тай хил залгаа худалдааны томоохон боомтууд эргэн нээгдэх хугацаанаас гадна ковидын цар тахал дахин гарах эсэх, Украин дахь Оросын түрэмгийллээс ирэх эдийн засгийн дарамтын мөрөөр Монгол Улс ямар арга хэмжээ авахаас үлэмж шалтгаална. Инфляци тасралтгүй нэмэгдэж, худалдааны саатал үргэлжилсээр байгаа нь мөнгөний болон төсвийн бодлогын орон зайг хумьж, улмаар эдийн засгаа хамгаалахын тулд макро эдийн засгийн бодлогоо үндсээр нь өөрчлөн зохицуулах төлөвлөгөөг шаардаж байна.

¹ Макро эдийн засгийн танилцуулга. ЭЗХЯ. 2023

² Азийн Хөгжлийн Банкны мэдээ, [Монголын эдийн засгийн өсөлт 2022 онд 2.3% дээр гацаж байгаад 2023 онд өсөх төлөвтэй байна — АХБ | Азийн Хөгжлийн Банк](#), 2022 оны IV сар

Нийлүүлэлтийн үрсгал алдагдан,, худалдааны саатал үргэлжилж, шатахууны үнэ нэмэгдэж байгаа нь бизнесийн зардлыг улам өсгөх тул 2022 онд инфляцийн дундаж түвшин 12.4%-д хүрэх магадлалтай байв. Төгрөгийн худалдан авах чадвар сулрах нь импортын барааны үнэд нөлөөлнө. Гэхдээ эдгээр асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр инфляци 2023 онд 9.3% болж буурахаар тооцоолсон ба бодитоор 7.6% байв³.

Эдийн засаг хэтдээ уруудах эрсдэл тулгамдаж буй нь БНХАУ-тай хил залгаа худалдааны гол боомтууд хаагдаад удсан, хязгаарлалт тогтоогдсон, Оросын Холбооны Улс болон Европтой хийх худалдаа саатаж болзошгүй байдал, түүнчлэн төлбөрийн тэнцэл, Засгийн газрын төсөвт Украины нөхцөл байдал гүнзгий нөлөөлсөөр байгаагаас үүдэлтэй. Чанаргүй зээлтэй холбоотой асуудал бүр дордож магад. Улмаар дотоодын санхүүгийн байгууллага, корпорациудын балансын хямрал нь өсөлтийн төлөвт ч, дунд хугацааны санхүүгийн тогтвортой байдалд ч хүндээр тусаж байна.

Ардчилал, хүний эрхийг дээдлэх зарчмын үхралт олон олон хандивлагч, хөгжлийн түншийн санааг чилээсээр.

2018 оны VI сарын байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт иргэний нийгмийн 17,634 байгууллага албан ёсоор бүртгүүлжээ. Эдгээрийн 15,241 нь “нийгэмд үйлчлэх”, 2,393 нь “гишүүдэдээ үйлчлэх” статустай. Эрүүл, хүчирхэг иргэний нийгмийг цогцлоон байгуулах амин сүнс болсон ТББ-ын тоо олон байгааг хөндлөнгийн ажиглагчийн зүгээс Монгол лугаа залуу ардчилсан орны хувьд маш чухал -үзэгдэл гэж дүгнэж болохоор хэдий ч эдгээрээс тогтмол, системтэй үйл ажиллагаа явуулдаг нь цөөн⁴.

Жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд бэлгийн цөөнх (ЛГБТКИА+)-ийг дэмжих олон нийтийн хандлага жилээс жилд нааштай болж байна:

Жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлага нь бэлгийн цөөнх хийгээд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн мэргэжлийн болон хувийн амьдралын боломж бололцоог хязгаарлаад зогсохгүй жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан болдог. Пипл-ин-Нийд Европын Холбоо

(ЕХ)-той хамтран бэлгийн цөөнх иргэдэд “Бахархлын өдөр” хэмээх арга хэмжээг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлдэг. Тус арга хэмжээнд 60 гаруй хувийн компани, элчин сайдын яам, ТББ нэгдэн орсон нь Пипл-ин-Нийдийн зүгээс анх 2019 онд дэмжих үед Ингэж дэлгэрүүлэх шаардлага бий юу?

Төрийн байгууллагын удирдлага болон нийгэмд нэр нөлөө бүхий зарим хүн уг арга хэмжээг эсэргүүцэх хандлагатай байсан ч иргэд, ялангуяа залуусын хандлага эерэг байсан нь сайшаалтай. Арга хэмжээнд саад хийсэн төрийн байгууллагын удирдлагыг Монголын ЛГБТ төвөөс “жагсаалт цуглаан хийх иргэний болон улс төрийн эрхийг зөрчсөн” гэх үндэслэлээр шүүхэд өгсөн бөгөөд энэ хэрэг нааштай шийдэгдвэл хууль хэрэглэний зөв жишиг тогтох юм.

Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдалд ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг болж⁵ үүнд бэлгийн цөөнхийн эрхтэй холбоотой 17 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд 15-ыг нь Засгийн газар нь хүлээн авчээ. Харамсалтай нь гэрлэлтийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрөх тухай зөвлөмжийг татгалзсан. Пипл-ин-Нийдийн зүгээс Монголын ЛГБТ Төвийг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх, тус улсын Засгийн газраар тэгш эрхээ хүндэтгүүлэхийн төлөөх нөлөөллийн ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсээр байх болно.

“Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-иар хэвлэн нийтлэх эрх чөлөө, жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарласан: Монгол Улсын Их Хурал 2020 оны IV сард коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор баталсан хуулиар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоох болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах бусад арга хэмжээг зохицуулах эрхийг Засгийн газарт олгосон.

Дээр дурдсан эрхээ хэрэгжүүлэхдээ хүний үндсэн эрхийг хангах ёстойг уг хуульд тэмдэглэсэн хэдий ч бодит байдалд цар тахлын - үеэр сэтгүүлчид,

³ Макро эдийн засгийн танилцуулга. ЭЗХЯ. 2023

⁴ Иргэний нийгмийн товч танилцуулга: Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк, 2019 он

⁵ www.ohchr.org/en/hr-bodies/upr/mn-index


иргэний нийгмийн идэвхтнүүдийг баривчлах, цагдан хорих тохиолдлыг олон удаа гаргаж, хэвлэн нийтлэх болон жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлаж байсан. Өдгөө улс орны хэмжээнд цар тахал намжсан атал энэ хууль хүчин төгөлдөр хэвээр байгаа нь сэтгэл түгшим. Тус хуулийг нэн даруй хүчингүй болгож иргэдийн, тэр дундаа сэтгүүлчийн үндсэн эрхийг бүрэн сэргээвэл зохино.

Гүтгэх гэмт хэргийн тухай хуулийн заалтын төсөл нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд заналхийлж байна: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.14-т худал мэдээлэл тараасан бол 600-900 орчим евротой тэнцэх төгрөгөөр торгох, 240-720 цаг хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, 1-3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж заасан. Аж ахуйн нэгжүүдийн хувьд тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллагыг 10,000 орчим евротой тэнцэх төгрөгөөр торгох ял шийтгэж болзошгүй.

Тус хуульд “худал мэдээлэл” гэсэн нэр томъёог тодорхойлоогүй нь Монголын хэвлэлийн эрх чөлөөний төлөө, мөн авлигын эсрэг тэмцэгч идэвхтэнүүдийн санааг зовоож байна. Бодит байдалд, гүтгэх гэмт хэргийг шийдвэрлэхээр ажиллаж буй цагдаа, прокурор, шүүгч нар хуулийн хариуцлага хүлээлгэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэл үнэн, худал нь нотлогдсон эсэхийг харгалзан үздэггүй гэж яригдаж буй.

Байгаль орчны чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд эрх зүйн зохицуулалт дутмаг байдалтай нүүр тулгарсаар: Монгол Улс цар тахлын дараа хилээ нээхтэй зэрэгцээд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт ихэссэн бөгөөд үүний дийлэнх нь БНХАУ-ын уул уурхайн компаниуд байна. Нутгийн иргэдтэй энэ талаар зөвлөлдөх нь хангалтгүй, эргээд тэдний зүгээс тавих хяналт сул. Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа байгаль орчны чиглэлээр ажиллаж байгаа ТББ, иргэдийн эвсэл, хөдөлгөөний чадавх сулаас гадна тэдний үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил илрэх, эсвэл ижил төстэй бусад байгууллагын сүрдүүлэгт өртөж дарагдах хандлагатай байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт их хэмжээний олборлолт хийгдэж буй газруудад олон нийтийн хяналтыг бий болгож, сайжруулахын тулд орон нутгийн ТББ-уудыг чадавхжуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэдний дунд сүлжээ бий болгох шаардлагатай. Энэ талаар анхаарч ажиллана.



2. Чиг үүрэг, Монгол дахь үйл ажиллагаа

Нийтлэг алсын хараа: Хүн ард нь чадавхаа бүрэн дүүрэн ашиглаж, хүртээмжтэй нийгэмд тогтвортой амьдрах боломжийг бий болгох эрмэлзлээр бид ажилладаг.

ПИН 40 гаруй улсад салбараа байгуулж, хүмүүнлэг, хөгжил, хүний эрхийн хөтөлбөр хэрэгжүүлж яваа 30 орчим жилийн туршлагатай олон улсын иргэний нийгмийн байгууллага. Чех,Их Британид төвтэй.

ПИН-ийн нийтлэг чиг үүрэг: Ядуурал, гадуурхыг бууруулж, хамгийн эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийн амьжиргааг тогтвортой түвшинд дээшлүүлэхийн төлөө тухайн улс, орон нутгийн оролцогчидтой хамтран ажиллана.

Монгол дахь чиг үүрэг: , Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, хүний эрхийг хүндэтгэх ухамсар, дадал төлөвшүүлэх замаар Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд тэгш боломж бүрдүүлэх, өөрчлөлтийн хөдөлгөгч хүч нь байхуйц түвшинд иргэний нийгэм хүчирхэгжихэд нь дэмжлэг үзүүлнэ.

Монгол дахь үйл ажиллагаа

ЗХУ задран унаснаас үүдэлтэй Монголчууд шинэ нийгэмд шилжих тэртээх хүнд 1993 оны өвөл ПИН 50 тонн хоол хүнс, хувцас хандивлахаар анх Монголд ирсэн түүхтэй.

2009-2011 оны зудаар Монголд дахин ирж, мөн онд байнгын ажиллагаатай салбараа байгуулжээ. Тэр цагаас хойш **21 аймгийг бүхэлд нь хамарсан гуч гаруй төсөл** хэрэгжүүлж, **хөдөө орон нутаг, хотын олон мянган хүний амьдралд** эерэгээр нөлөөлж чадсан. Эдгээр төслөөрөө **уур амьсгалын өөрчлөлт, амьжиргааны тогтвортой байдал, хүмүүнлэгийн яаралтай түслэмж, жендэр ба нийгмийн хүртээмж, иргэний нийгмийг хүчирхэгжүүлэх, сайн засаглал,** түүнчлэн **боловсрол, ур чадвар** хөгжүүлэх салбарт голлон төвлөрч ирлээ.

Хамтрагч талууд

Пипл ин Нийд гол оролцогч талуудаа мөн хамруулан хандивлагчдын оролцооны цогц төлөвлөгөө боловсрууллаа. Манай гол хамтрагчид бол судалгааны байгууллага, их сургууль, орон нутгийн захиргаа, Засгийн газар, яамд болон тэдгээрийн хэрэгжүүлэгч агентлагууд юм.

Үүнээс гадна хөгжлийн зорилго, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг хазаарлахад туслах хүчирхэг засаглалыг бүрдүүлэхэд нөлөөлөх чухал бүлэг болохынх нь хувьд иргэний нийгмийн манлайллыг ПИН бүрнээ хүлээн зөвшөөрч, дэмждэг.Өнгөрөгч жилүүдэд иргэний нийгэм олон улсын ТББ-уудтай мөр зэрэгцэн ардчиллын үнэт зүйлсийг дээдлэн ажиллаж, хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд нөлөө бүхий институтц болжээ.

ПИН-ийн Монгол дахь хөтөлбөрийн үнэт зүйл, алсын хараа ижил төстэй орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд, идэвхтнүүдтэй үр өгөөжтэй түншлэхийг чармайхын зэрэгцээ тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэхэд туслах замаар Монголын иргэний нийгмийг хүчирхэгжүүлэх амлалт өгч, үүрэг хүлээн ажиллаж байна. Ялангуяа иргэний нийгмийн болон хувийн хэвшлийнхний дуу хоолойнд хүч нэмэхээр үл зогсон, үйлдэл хийх түвшинд хүчирхэгжүүлэхэд тэднийг татан оролцуулж, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ.

Өнгөрсөн хугацаанд хамтарсан хийгээд одоо хамтарч буй бүх талтай бид нягт харилцаатай бөгөөд тэдний өмнө үнэ цэнээ бид батлан харуулсаар байна. Эдгээр хамтрагч талын олонх нь ПИН-тэй хамт консорциумд нэгдэж, зарим нь нэгдэх сонирхлоо илэрхийлээд байна. Ийм хамтын ажиллагаа, түншлэл бүрдүүлж чадсанаар ПИН дангаараа хэрэгжүүлж үл чадах томоохон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт (*Азийн Хөгжлийн Банк, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Ардчилал, хүний эрх, хөдөлмөрийн товчоо гэх мэт*)-ийг босгосон билээ. Бидний хамтын ажиллагаа, түншлэлийн сүлжээнд нэгдэх сонирхолтой бол 2022 оны **Хандивлагчдыг татан оролцуулах төлөвлөгөөг** харна уу.

ПИН урьдын болон одоогийн түншлэлдээ тулгуурлан, тогтвортой түвшинд сайн үр нөлөө бий болгохын тулд зорилго нэгтэй байгууллагуудтай

стратегийн түншлэл хөгжүүлж, түншлэлийнхээ сүлжээг улам өргөжүүлэн,
төрөлжүүлсээр байх болно.



3. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд

ПИН Монгол өмнөх стратеги болон гадаад нөхцөл байдал, өөрчлөгдөн буй орчинд хийсэн дүн шинжилгээнээс гадна хуримтуулсан мэдлэг, туршлагадаа үндэслэн дор дурдсан гурван тулгуур бүхий хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж байна.

1. I тулгуур: Хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх, нөхөн сэргээх
2. II тулгуур: Уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах
3. III тулгуур: Иргэний нийгэм ба хүртээмжтэй засаглал бий болгох

Хүмүүнлэг энэрэнгүй ёс, эрх чөлөө, эрх тэгш, тогтвортой байдлын үзэл санаанд тулгуурласан төрийн бус, ашгийн бус байгууллага болохын хувьд Монгол дахь үйл ажиллагаа болон үнэт зүйлсийн маань үндэс суурь нь эдгээр шалгуур юм.

Хүмүүний нэр төр, эрх чөлөөг бид язгуур үнэт зүйлсээ гэж үздэг. Хүн хаана ч байсан хувийн амьдралаа өөрөө шийдэх, **Хүний эрхийн түгээмэл тунхаглалд** тусгагдсан эрхээ эдлэх боломжтой байх учиртай.

ПИН-ий эдгээр дээр дурдсан чиглэл тус бүр бидний хамтрагч талуудын стратеги, чиглэлтэй мөн уялдаатай. ЕХ-ноос 2025 он хүртэлх хугацааг хамруулан Монгол Улсад зориулж гаргасан зураглалд “уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөг нь бууруулах, тэр дундаа нүүрстөрөгч багатай, нөөц баялагт хэмнэлттэй, экологид ээлтэй тойрог эдийн засагт шилжих”-д⁶ иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг чухал нөлөөтэй болохыг онцлон тэмдэглэсэн байдаг. Монгол Улс дахь гол хамтрагчдын тэргүүлэх зорилтуудыг тодотгон давтахуй дор Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын хөтөлбөрийн гол чиглэл **байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх байдлыг төлөвшүүлэхэд** төвлөрөхийн сацуу **иргэний нийгэмтэй** харилцан уялдаат хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ.

I тулгуур: Хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх, нөхөн сэргээх

Монгол Улс гамшгийн эрсдэл багатай гэсэн ангилалд багтах боловч сүүлийн таван жилд шуурга, үер, зуд, орчны бохирдол, өсөн нэмэгдэж буй газар хөдлөлт, Ковид-19 цар тахал зэрэг хүмүүнлэгийн туслалцаа шаардсан бэрхшээлтэй учирч байна. ПИН-ийн зүгээс гамшгийн бэлэн байдлыг өндөр түвшинд хангах чиглэлээр хувь нэмрээ оруулж байна.

ПИН түншүүдтэйгээ хамтран гамшигт өртөгсдийн амь насыг аврах, тэдний зовлон зүдгүүрийг нимгэлэх, хүн хэмээх эрхэм чанарынх нь үүднээс тэдэнтэй харьцах замаар цаг үеэ олсон хүмүүнлэгийн тусламжийг чанарын өндөр түвшинд, тохирох төрөл, хэлбэрээр, зарчимч арга барилаар үзүүлэх, улмаар нөхөн сэргэж, хэвийн байдалдаа ороход нь туслан, гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ажиллана. Ингэхдээ бид хүмүүнлэг ёс, шударга, төвийг сахисан, хараат бус байх суурь зарчмыг чанд баримталдаг. Гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх гэсэн гурван чиглэлийг баримтлахын сацуу Монгол Улсыг онцгойлон анхаарч, хэрэгцээ шаардлагад нь тулгуурласан, орчин нөхцөлд нь нийцсэн тусламж үзүүлж байна.

Монголд хамгийн эмзэг нөхцөлд байгаа хүмүүст хэвийн амьдралдаа эргэн ороход нь зориулж ПИН **2017 оноос хойш нэг сая гаруй ам.долларын хүмүүнлэгийн тусламж** үзүүлсэн. Эдгээрээс хэдэн жишээ дурдвал:

- 2009 оны зуднаар **хамгийн их хохирол амссан** малчдад хоол хүнс, өвлийн хувцас хунар, эм тариа, халаалтын зуухны түлш, утасны нэгж, орон нутаг хоорондын тээврийн зардлыг багтаасан тэдний суурь хэрэгцээг хангах тусламж үзүүлсэн. 2021 онд баруун гурван аймгийн **381 өрхөд мөнгөн тусламж олгосон.**
- Ковидын цар тахлын нөлөөнд өртсөн, хамгийн эмзэг нөхцөлд байгаа иргэдэд туслах зорилгоор Монгол Улсын Засгийн газартай хамтран яаралтай тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлсэн. Өрх толгойлсон хүүхэд, ганц бие эцэг, эх, дотуур байрны оюутан, ХДХВ-ын халдвартай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй амьдардаг иргэд болон эмзэг бүлгийн айл

⁶ Монгол дахь Европын холбооны төлөөлөгчийн газар. Огноо заагаагүй. Монгол Улсад 2021-2025 онд иргэний нийгмийн оролцоог хангах талаар Европын холбооноос боловсруулсан зураглал.

өрх гээд **нийт 5000 гаруй өрхөд талон, хүнсний багцын** буцалтгүй тусламж олгосон.

Цаашилбал, Монгол Улсын Засгийн газраас саяхан баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д нийцүүлэн **хамгийн эмзэг нөхцөлд байгаа тэдгээр иргэдийг байгальд ээлтэй замаар хэвийн амьдралдаа аль болох түргэн ороход нь дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.** Үүнтэй холбоотойгоор бид дараах үйл ажиллагааг явуулна:

- Эмзэг бүлгийн иргэдийг гамшгийг даван туулах чадавхтай болгох;
- Гамшигт өртсөн зорилтот бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэх;
- Дотоодын болон олон улсын төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний салбарынхан, төрийн байгууллагуудтай урт хугацааны түншлэл тогтоох.

II тулгуур: Уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах

- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд ПИН-ийн гүйцэтгэх үүрэг бол уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтолд өртөмтгий хүмүүсийн гамшгийг даван туулах чадавхыг сайжруулахын зэрэгцээ байгальд ээлтэй өсөлт дэвшил, ногоон хөгжил, эдийн засгийн тойрог зарчмуудад нийцсэн шийдлээс гадна хүлэмжийн хий ялгарлыг бууруулах, нүүрстөрөгчийг агаар мандлаас зайлуулж нөөц бэлтгэх хувилбараар аль болох олон шийдэл гаргахыг хичээх явдал юм. Монгол Улс нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаралт дэлхийн дунджаас бараг хоёр дахин их, Азидаа хамгийн өндөрт тооцогдох орнуудын нэг боллоо. Тус улс уур амьсгалын өөрчлөлтөд өртөж, сөрөг нөлөө нь хүүхэд багачууд, өндөр настан, орлого багатай өрхүүдэд илүү хүндээр тусаж байна. Ялангуяа байгаль орчны бохирдлоос болж Монголчуудын эрүүл мэндэд урт хугацааны ноцтой эрсдэл учирч болзошгүй бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр улам эмзэгших төлөвтэй байгааг онцлон анхаарч, **орчин нөхцөлд нь дорвитой нийцсэн дасан зохицох хөтөлбөрүүдийг** эн тэргүүнд чухалчилдаг. Монгол хүний эрүүл мэндэд урт хугацааны хийгээд ноцтой хохирол үзүүлж болзошгүйгээр зогсохгүй эмзэг байдлыг

улам нэмэгдүүлэх төлөвтэй байгаль орчны бохирдлын эсрэг хөтөлбөр хэрэгжүүлэхийг ПИН эрхэмлэж байна. Энэ чиглэлээр бид дараах үйл ажиллагаа явуулна: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй тэжээллэг хоол хүнсээр хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх;

- Агаар, хөрс, усны бохирдол зэрэг хүрээлэн буй орчны сөрөг хүчин зүйлсийг бууруулах;
- Уур амьсгалд тохирсон эрчим хүчний ухаалаг шийдлүүд боловсруулах, түрших, өргөжүүлэх;
- Байгаль орчин бохирдуулагчдын хүлээх хариуцлага, ил тод байдлыг хангах;
- Байгаль орчны бохирдлыг хянах, үнэлгээ хийх, бууруулах чиглэлээр орон нутгийн чадавхыг бэхжүүлэх;
- Иргэний нийгмийг уур амьсгалын өөрчлөлт, ногоон эдийн засагт шилжихтэй холбоотой үйл ажиллагаа явуулахад нь дэмжих.

Монгол Улсын амлалттай үялдуулан уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн ухаалаг шийдэл, ногоон хөгжлийг дэмжих үүднээс уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн оролцоог хангах, зан үйлийн шинжлэх ухааны мэдлэгийг ашиглах замаар түншлэгчдийнхээ хамт бид ажиллана **Агаарын бохирдлыг хараат бусаар хянах, тайлагнах чиглэлээр** тэргүүлэгч байгууллагуудын нэг болохын хувьд Монголын иргэд, олон нийтэд дараах дэмжлэг үзүүлнэ:

- Нийгэм, зан үйлийн өөрчлөлтийн аргыг ашиглан орон нутгийн засаг захиргаа, оюутан сурагчид, олон нийтэд байгаль орчны бохирдлын үр дагаврыг таниулах нөлөөллийн үйл ажиллагаа, чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх (*энэ талаар www.behaviourchange.net-ээс дэлгэрүүлэн үзнэ үү*);
- Технологийн дэвшил ашиглан бохирдлын шалтгаан болон шийдлүүдийг ойлгож, зураглал гаргах (агаарын чанарын хяналт, дрон зураглал, агаарын чанарыг үнэн бодитой мэдээлэх хариуцлага);
- Өрхийн түвшинд уур амьсгалд тохирсон ухаалаг, байгаль орчинд ээлтэй техникийн шийдэл гаргах (*жишээ нь, мал аж ахуй,*

цэцэрлэгжүүлэлт, Монгол гэрт зориулсан дулаан тусгаарлалт, орчин үеийн халаалт, дулаалга), тогтвортой үнэ цэнийн гинжин хэлхээг үүсгэх;

- Орон нутгийн иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшил, хот, суурин газар болон бэлчээрийн орчныг хамгаалах сайн засаглал, сүлжээ бий болгох чиглэлээр орон нутгийн захиргааг чадавхжуулах, хөшүүрэг хэрэглэн нөлөөлөх;
- ПИН-ийн боловсруулсан Улаанбаатар хотын агаарын чанарыг автомат боловсруулалттай алгоритмаар урьдчилан таамагладаг загварын хэрэглээг тогтворжуулах.

III тулгуур: Иргэний нийгэм ба хүртээмжтэй засаглал

ПИН орон нутгийн оролцогчдыг чадавхжуулах амлалт үүргийнхээ хүрээнд Монгол дахь зорилтот бүлгүүдэд төвлөрч нийгэм, эдийн засаг, ардчиллын хөгжилд гол үүрэг гүйцэтгэхэд нь иргэний нийгэмд дэмжлэг үзүүлж ирлээ. Үүний хүрээнд ТББ-уудад засаглал, хөгжилд илүү үр дүнтэй оролцож чадах түвшинд техникийн үр чадвараа дээшлүүлэх, зохих горим боловсруулахад тусалдаг. Түүнчлэн, иргэдийн оролцоотой ардчиллын үйл явцыг шат ахиулах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хэлбэрээр хөгжүүлэх үйлсэд төрийн байгууллагуудтай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлж байна. Тодруулбал, төрийн бодлого, үйлчилгээ нийгэмд хүртээмжтэй, хүний эрх, жендэрийн тэгш байдлын зарчимд нийцсэн байх явдлыг бататгахын тулд **ЛГБТИК+ гэх мэт гадуурхагдсан иргэд болон залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй амьдардаг иргэд зэрэг иргэний нийгмийн төрөл бүрийн оролцогчид**, эмэгтэйчүүдийг чадавхжуулах бүлгүүд, бусад талуудыг зорилтот бүлгээр сонгон ажилладаг.

Үүний зэрэгцээ ардчилсан үйл явцад оролцох, төрийн албан тушаалтнуудаас хариуцлага нэхэх, **хүний эрхийг** хэрэгжүүлэх зэргээр идэвхтэй байр суурьтай **иргэн** байх чиглэлээр тэдгээр зорилтот бүлгийг чадавхжуулж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шударга ёсыг хөхиүлэн дэмжиж байна.

ПИН хүртээмжтэй, сайн засаглалыг дэмжих зорилго тээн, тогтвортой үр дүнд хүрэхийн тулд орон нутгийн түвшинд шийдвэр гаргах хүртээмжтэй, шударга ажиллагаанд олон нийтийг идэвхтэй оролцуулахад голлон

анхаарч, иргэний нийгэм, Засгийн газар, олон нийтийн үр дүнтэй хамтын ажиллагааг чухалчилдаг. Тиймээс бид дор дурдсан зорилго өөд чиглэн, мэргэшсэн түвшний үр чадвар, туршлага хуримтлуулж байна:

- Орон нутгийн эрх бүхий байгууллага, шийдвэр гаргагчдын **чадавхыг бэхжүүлэх**
- **Орон нутгийн иргэдийн** дуу хоолойг шийдвэр гаргагч үндэсний болон олон улсын байгууллага, албан тушаалтнуудад хүргэх
- Олон нийт, иргэний нийгмийн байгууллага болон төрийн байгууллага хоорондын зөвшилцөл, яриа хэлцлийг дэмжих, сайжруулах
- **Ард иргэдийнхээ өмнө орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хүлээх хариуцлагыг өндөрсгөж**, тэдний орон нутгийн хэрэгцээ шаардлагын дагуу байж болох эрсдэлийг тооцож, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах чадварыг сайжруулах

Үүнээс гадна орон нутгийн иргэний нийгмийн манлайллыг эн тэргүүнд чухалчилснаар илүү хүртээмжтэй хөгжих, хүмүүнлэгийн арга хэмжээний үр дүнг ахиулах түвшинд хүргэх боломжтой. Хөгжлийн болон хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь ирээдүйд иргэний нийгмийн байгууллагын санаачилга, удирдлагын дор явагддаг байхын зэрэгцээ төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэх ёстой. ПИН нийгэм, зан үйлийн өөрчлөлт, үр чадвар хөгжил, тогтвортой амьжиргаа, уур амьсгалд нийцсэн ухаалаг хийгээд ногоон шийдлийн зах зээл, санхүүжилтийг дэмжих чиглэлээр ажиллаж ирлээ.

- ПИН **иргэний нийгмийн 10 байгууллага, 40 хоршоотой** хамтран ажиллаж, зах зээлд нэвтрэх, санхүүжилтийн боломжоо тэлэхэд дэмжлэг үзүүлэв.
- **Хэвлэл мэдээллийн салбарын бие даасан, тогтвортой байдлыг** хангах үүднээс хөрөнгө оруулалт, санхүүжилт бүрдүүлэх талаар орон нутгийн **сэтгүүл зүйн** байгууллагуудтай хамтран ажилладаг.
- Санхүүгийн боломжоо бүрдүүлэхэд нь иргэний нийгмийн байгууллагуудад туслах үүднээс тэдний хэрэгцээнд нийцсэн шинэлэг хэлбэрээр **чадавх бэхжүүлэх** ажлыг зохион байгуулдаг.

САЛБАР ДАМНАСАН ЧИГЛЭЛҮҮД

Зах зээлийн систем хөгжүүлэлт

ПИН-ийн баримталдаг зах зээлийн систем хөгжүүлэлтийн гол арга барил нь амьжиргааны түвшин багатай иргэдэд чиглэсэн хөгжлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар өргөн цар хүрээтэй үр нөлөө, **тогтвортой байдлыг** бий болгоход чиглэдэг.

Хамгийн ядуу, хамгийн алслагдсан газар аж төрж байгаа иргэд **үйлдвэрлэгч** (*жижиг ферм, бичил бизнес эрхлэгчид*), **хэрэглэгч** (*бараа, үйлчилгээ худалдан авагч, хэрэглэгчид*), **ажилтан** гэсэн бүрэлдэхүүнтэй зах зээлд түшиглэн амьдардаг. Гэвч тэрхүү зах зээлийн үр шим нь уг зорилтот бүлгийн хүмүүст тэр бүр хүрч чаддаггүй тул борлуулагч, үйлчилгээ үзүүлэгч, үндэсний компани, төрийн байгууллага гэх мэт оролцогч талууд зан үйл, дадлыг өөрчлөхөд чиглэсэн зах зээлийн тогтолцооны хөгжилд хувь нэмрээ оруулахыг зорьдог.

Зах зээлийн систем хөгжүүлэлтийн багц хэрэгсэл нь бидний хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд дараах байдлаар туссан байна:

- **Зах зээлд суурилсан эрчим хүчний хэмнэлттэй шийдлийг дэмжих замаар ногоон сууринг бий болгох**
- Эмзэг бүлгийнхэнд өөрсдийнх нь ахуй амьдрал, байгаль орчинд эерэгээр нөлөөлөх бүтээгдэхүүн, үйлчилгээ хүлээн авах **боломж, сэдэл** төрүүлэх, нэмэгдүүлэх (*жишээлбэл, орон нутагт үйлдвэрлэсэн хүнс, ундаа гэх мэт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, санхүүгийн үйлчилгээ, нарны зайгаар ажилладаг гэрэл, био шингээгч зэрэг сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүн*)
- **Мэргэжлийн болон зөөлөн үр чадвар олгох** сургалтаар дамжуулан үр чадвараа хөгжүүлэх боломжийг дэмжих, ажилд орох боломжийг нь сайжруулах.

Жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоо

Жендэрт суурилсан хандлага нь жендэрийн тэгш бус байдал эмзэг бүлгийн иргэдэд харилцан адилгүй нөлөөлдгийг харуулахаас гадна жендэрийн

тэгш бус байдлыг арилгаж, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэхэд туслах өөрчлөлтийн механизм болдог.

ПИН жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоо (*ЖТБНО*)-ны бодлогоо бүрэн хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргана. Орчин нөхцөл нь тохиромжтой хийгээд эерэг үр нөлөө авчрахаар байвал эрхээ эдлэх, үүргээ биелүүлэхэд нь хүмүүсийг дэмжих үүднээс хүний эрхэд суурилсан хандлагыг үндэсний хууль, бодлоготой нийцүүлэн хэрэгжүүлнэ. Хөвгүүд, эрэгтэйчүүдийн тодорхой сэтгэл хөдлөл, үйлдлийг хязгаарладаг нийгэмд хортой хэм хэмжээ, хэвшмэл ойлголт Монголд бий. Тодруулбал, эрэгтэй хүнийг хүчтэй байх гэсэн ойлголтоор тодорхойлж, сэтгэл хөдлөлөө харуулбал сул дорой гэх хандлага түгээмэл. Энэ нь эргээд эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, амь насанд халтай аливаа буруу зуршлаас өөрийгөө хамгаалахад нь сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн, уг хандлагаас хамааран эрэгтэйчүүд хүчирхийллийг эрх мэдлээ тогтоох, хянах хэрэгсэл болгон ашиглах ба энэ нь цаашлаад дотны хүмүүсээ хүчирхийлэхэд хүргэдэг.

Энэ асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахын тулд бид дараах зүйлийг хийнэ:


- Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх бүхий л үе шатанд жендэрийн тэгш байдал, оролцоо, хамгааллын зарчмуудыг хангаж, жендэрийн нарийвчилсан үзүүлэлтүүд бүхий мэдээллүүдийг цуглуулах;
- Тусгаарлах, хүйсээр ялгаварлах, хамгаалахтай холбоотой эрсдэлүүдийг зохицуулах ажилтнуудын мэдлэг, чадавхыг бэхжүүлэх; жендэрийн тэгш байдлыг хангахад тасралтгүй суралцахыг хөхиүлэн дэмжих;
- Төслийг төлөвлөхөөс эхлээд хэрэгжүүлэх бүхий л шатанд, түүнчлэн бүхий л үйл ажиллагаа, харилцаа, нөлөөлөлд жендэр, оролцооны асуудлыг тусгах;
- Жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхсан аливаа дадлыг үл дэмжих стратегийг ПИН-ийн бүх харилцаанд баримтлах;
- Монголын эмэгтэйчүүд болон нийгмээс тусгаарлагдсан бүлгийнхэнд тулгарч буй саад бэрхшээл, сорилтуудыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх алхам, шийдлүүдийг хэрэгжүүлэх хөтөлбөрт тусгах;

- Жендэрийн тэгш бус байдал, нийгмийн тусгаарлах үзэгдэлтэй тэмцэх оновчтой дадлыг дэмжиж, аливаа шийдвэрийг жендэрийн өнцгөөс харсан байхад идэвхийлэн нөлөөлөх.

Үүнээс гадна ПИН Монгол нь олон нийтэд зөв зан үйлийн дадлыг бэхжүүлэхийн тулд “Нийгмийн зан үйлийг өөрчлөх аргачлал” болон “Саад бэрхшээлийн дүн шинжилгээ” хэмээх туршилтаар батлагдсан хоёр арга хэрэгслийг үйл ажиллагаандаа шингээн хэрэгжүүлдэг. Нэн ялангуяа зан үйлийн өөрчлөлтийн хүрээнд бид дараах зүйлийг анхаардаг:

- Зөв дадалтай болоход нь хүмүүст юу саад болж байгааг ойлгох
- Зөв дадлыг төлөвшүүлэхэд хүмүүст юу түлхэц болж болохыг мэдэх
- Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг таслан зогсоох гэх мэт аливаа үйл ажиллагаа, хөтөлбөрт зан үйлийн өөрчлөлтийг хэрхэн тусгаж болохыг ойлгох
- Зан үйлийн өөрчлөлт бүхий үйл ажиллагаа, хөтөлбөрийг хамгийн сайн чанартайгаар хэрэгжүүлэх, үнэлэх

Бид Монгол болон бусад улс оронд ажиллаж, хуримтлуулсан цогц туршлага, мэргэшсэн мэдлэг, үр чадвараас гадна төв байгууллагын Мэдлэг, суралцахуйн албаны зөвлөхүүдийн мэргэжлийн туслалцаа, дэмжлэгт үндэслэн дээр дурдсан зорилго, зарчмаа баримтлан ажилладаг. Мөн байгууллагын мэдлэг, суралцахуйн алба нь боловсрол, үр чадвар, зах зээлийн систем хөгжүүлэлт, бизнес, жижиг болон бичил аж ахуйн нэгжүүд, уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоо, хамгаалал, тэгш байдал, зан үйлийн өөрчлөлт зэрэг төрөл бүрийн чиглэлийн мэргэшсэн мэдлэг, туршлагаар тухайн улс орны хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлдэг.



4. Хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй төслүүд

Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь төсөл (2023-2026, Европын Холбоо).

Тус төслийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран ажиллах замаар “Пипл ин нийд” ОУТББ болон ФАРО Фаундэйшн ТББ хэрэгжүүлж байгаа бөгөөд үндсэн зорилго нь иргэний нийгмийн байгууллагууд хүртээмжтэй цахим шилжилт, ардчилсан тогтолцоонд Монгол Улсын Засгийн газрын Цахим Үндэстэн болох зорилтод нийцүүлэн идэвхи, санаачилгатай хамтран ажиллаж, бие даасан оролцочид болоход туслах юм. 744,445 евро

Эдийн засгийн ногоон шилжилт (2022–2025 он, EX-SВИЧ / SWITCH):

Монгол Улсад хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, ундааны эко шошго, хаягжуулалтын тогтолцоо бий болгож, байгаль орчинд ээлтэй хүнс үйлдвэрлэлийн зарчмыг хөхиүлэн дэмжих төсөл – 2.2 сая евро

Цэвэр агаар болон уур амьсгалын өөрчлөлтийн төлөөх хүүхэд, залуусын сүлжээ (2021 он, НҮБ-ын Хүүхдийн Сан):

Монголын томоохон хотуудад социал мэдээ, хэвлэл мэдээллийн уламжлалт хэрэгсэл болон мессэжээр дамжуулан 15-24 насны хүүхдүүдэд цэвэр агаар, уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээлэл өгөх, тэднийг эдгээртэй холбоотой асуудалдоролцуулах төсөл – 112,796 евро

Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох нь (2021–2022 он, НҮБ-ын Хүн амын сан):

Орон нутгийн түвшний урьдчилан сэргийлэх механизмаар дамжуулан жендэрийн тэгш байдлыг дэмжих хэм хэмжээг тогтоох замаар жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхыг дэмжих төсөл – 74,000 ам.доллар

Хараат бус хэвлэл мэдээллийн төсөл (2021–2022 он, “Спирит ов Америка” байгууллага, Америкийн элчин сайдын яам):

Хэвлэл мэдээллийн салбарт тогтвортой бизнесийн шинэлэг загваруудыг нутагшуулан тэлэхэд зах зээлд суурилсан арга барилаар хөрөнгө оруулж, хараат бус тогтолцоог бэхжүүлэх зорилготой төсөл – 13,0000 ам.доллар

Ковидын үеийн яаралтай түслэмж (2020 он, Швейцарын хөгжлийн агентлаг, Германы элчин сайдын яам, ПИН-ийн төв байгууллага):

Ковид – 19 цар тахлын улмаас эдийн засгийн хохирол амссан хүмүүст хүнсний бүтээгдэхүүн, эм тариа авах эрхийн бичиг, боловсрол, ариун цэвэр, эрүүл ахуйн дэмжлэг үзүүлэх төсөл – 250,000 ам.доллар.

КашЭвал / CashEval (2021–2023 он, ХБНГУ-ын Гадаад хэргийн яам):

Зудын эрсдэлтэй бүсэд амьдарч байгаа өрхүүдэд цаг алдалгүй арга хэмжээ авахад нь зориулан ямарваа нөхцөл болзолгүйгээр мөнгөн тусламж үзүүлэх замаар зудын гамшгийг даван туулах чадавхыг нь дээшлүүлэх төсөл – 199,856 евро

ЧИП / CHIP (2020–2024 он, НҮБ-ын Хүүхдийн Сан, Швейцарын хөгжлийн агентлаг):

Халаалт, дулаалгын бүтээгдэхүүн, үйлчилгээнд уур амьсгалд тохирсон ухаалаг шийдэл нэвтрүүлэх замаар монгол гэрт амьдардаг өрхүүдийн эрчим хүч хэмнэх, агаарын бохирдол бууруулах дадлыг сайжруулах төсөл – 332,929 евро

Агаарын бохирдол хянах цахим платформ –

ХэйзГэйзер / HazeGazer (2020–2022 он, НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн Сан):

Олон нийт болон иргэний нийгэмд мэдээлэл хүргэхэд чиглэсэн НҮБХХ-ийн хүчин чармайлтыг дэмжих зорилгоор агаарын чанарын зураглал хийх, агаарын бохирдлын талаар мэдээлэлжүүлэх аян зохиох төсөл – 110,000 евро

АБЗ – Агаарын бохирдлыг зогсоох (2018–2021 он, EX-SВИЧ / SWITCH, Чехийн хөгжлийн агентлаг):

Олон нийтэд түшиглэсэн дрон зураглалаар дамжуулан Улаанбаатар хотод тогтвортой орон сууц барих ногоон санхүүжилт, эрчим хүчний зөвлөгөө

өгч дэмжих замаар агаар, орчны бохирдлыг бууруулах төсөл – 499,081 евро

R2B – Амьсгалах эрх (2018–2019 он, ЕХ, Ардчилал ба хүний эрхийн төлөөх Европын хэрэглүүр):

Агаарын чанарын хяналтын сүлжээ байгуулж, ил тод, хариуцлагатай байдлыг дэмжихийн зэрэгцээ иргэний нийгмийн түвшинд үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл – 314,590 евро

Гамшгийг даван туулах чадавх сайжруулахад уламжлалт болон шинэ технологи ашиглах нь (2016–2019 он, Чехийн хөгжлийн агентлаг, Европын холбооны хүмүүнлэгийн тусламжийн салбар, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага):

Зүүн аймгуудын зудад нэрвэгдсэн малчдын гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх, эрт сэрэмжлүүлэх тогтолцоогоор дамжуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулах, гар утсаар цаг агаарын мэдээ түгээх төсөл – 526,547 евро

EPIL (2016–2019 он, иргэний нийгмийн байгууллагууд-улс, орон нутгийн эрх бүхий байгууллагууд, Чехийн хөгжлийн агентлаг):


Архангай, Өвөрхангай аймагт хоршоодын чадавхыг бэхжүүлэх замаар тогтвортой амьжиргааг дэмжих төсөл – 932,697 евро

Таван хошуу мал, ан амьтдын харилцан нөлөөллийг ойлгох судалгааны чиглэлээр Чех, Монголын их дээд сургуулиуд хамтран ажиллах нь (2017–2018 он, Чехийн хөгжлийн агентлаг):

Бэлчээрийн экологийн харилцан үйлчлэлийн талаарх дээд боловсролын агуулгыг сайжруулах, байгалийн баялгийн зохистой менежментийг хөхиүлэн дэмжих төсөл – 103,000 евро

Хонины ноосон дулаалга (2013–2015 он, ЕХ, СВИЧ / SWITCH, Чехийн хөгжлийн агентлаг):

Хонины ноосыг барилга байгууламжийн дулаан тусгаарлалтад ашиглах байгальд ээлтэй, эрчим хүчинд хэмнэлттэй шийдэл хэмээн сурталчлах, тогтвортой амьжиргааг дэмжих үнэ цэнийн гинжин хэлхээний хувилбарууд боловсруулах төсөл – 891,412 евро



5. Хавсралт

Тус улсад хэрэгжүүлж буй хөтөлбөр

Монгол Улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрт хяналт шалгалт хийхийн өмнө [хяналтын хуудсаа](#) жилд хоёр удаа шинэчилдэг. Төв захиргааны ажилтнуудын санал сэтгэгдэлд үндэслэн, тус улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэн сайжруулах шаардлагатай сорилт бэрхшээл болон асуудлуудыг хяналтын хуудас ашиглан чухалчлалын дарааллаар нь эрэмбэлнэ.

Хүүхэд, насанд хүрэгчдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах бодлого?

Хүүхэд, насанд хүрэгчдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах нь ПИН-ийн ажилтнууд, хамтрагчид байнга баримталбал зохих ёс зүйн дүрмийн нэгэн үндсэн хэсэг юм. Хамгааллын дадал, арга хэмжээг нягт хянаж, хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүн хүч бүрдүүлж уг чиг үүргийг хүлээлгэсэн байх ёстой. ПИН-ийн ажилтнууд, түншүүд, ханган нийлүүлэгчид болон манай байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй бусад оролцогчдын зүгээс төслийн үр шимийг хүртэгчдэд хор нөлөө үл учруулах явдлыг бататгах, хүүхэд, насанд хүрэгчдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалахыг бид хамтын хариуцлага гэж үздэг. Бид хамгааллын бүхий л арга хэмжээг хөтөлбөрүүддээ тусгах, ажилтнууд, түншүүдэдээ энэ талаар тодорхой мэдээлэх, холбогдох бодлого, журмуудыг баримтлах замаар хамгааллын механизмыг хэрэгжүүлэх алхмуудыг байнга хийх амлалттайгаар ажиллаж байна. Хамгааллын арга хэмжээг оновчтой дадлаар хэрэгжүүлэх, хувьсан өөрчлөгдөж, хөгжиж буй орчин нөхцөлөөс сургамж авахын тулд жил бүр гүйцэтгэлээ эргэн хянадаг.

Эрсдэлийн төлөвлөгөө

Монгол дахь ПИН-ийн хөтөлбөрийн газар тус улсад хэрэгжүүлэх стратегийн зорилгоо хангахад нөлөөлөх магадлалтай гадаад эрсдэлүүд, тэдгээрийг арилгах арга хэмжээг дурдсан төлөвлөгөөтэй. Энэхүү төлөвлөгөөг тухайн улс орны нөхцөл байдал, цаг үеийн өөрчлөлттэй холбон байнга шинэчилдэг 2022 оны дунд үеийн эрсдэлийн төлөвлөгөөг эндээс [холбоосыг](#) үзнэ үү.

Гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө буюу Шилжилтийн төлөвлөгөө

ПИН-ийн Монгол дахь хөтөлбөр нь анх 2018 онд гамшгийн үеийн бэлэн байдлын иж бүрэн төлөвлөгөө (ГҮББТ)-г төв захиргааны мэргэжилтнүүдийнхээ арвин туршлагад түшиглэн үндэсний салбарынхаа ажилтнуудтай нягт хамтарч боловсруулсан. 2022 онд тухайн үеийн орчин нөхцөл, хандивлагчдаас санхүүжилт олгох амлалт үүрэг зэрэгт үндэслэн ГҮББТ-г шинэчилсэн.

ГҮББТ болон холбогдох бусад баримт бичгүүдийг эндээс үзээрэй.


Санхүүжилтийн стратеги

ПИН-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хөрөнгө босгох стратегийг эндээс [холбоосыг](#) үзнэ үү.

ХЯНАЛТ–ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ХАРИУЦЛАГА, СУРАЛЦАХУЙ

ПИН Монгол хяналт–шинжилгээ, үнэлгээ, хариуцлага, суралцахуйн тогтолцоог бүхэлд нь дүрсэлсэн тусгай удирдамжтай энэ нь ПИН-ийн төв байгууллагаас баталсан нийтлэг стандарттай нийцдэг билээ. үнэлгээ, хариуцлага, Энэхүү удирдамжийг мөрдсөнөөртөслийн үзүүлэлтийг цаг тухайд нь үнэн зөв тайлагнах, төслийн үр дүнг чанарын өндөр түвшинд хангах, дотоод, гадаад үнэлгээг чанартай гүйцэтгэх, хандивлагчид, орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудын өмнө өндөр хариуцлагатай ажиллах баталгаа болдог юм.

Хяналт – шинжилгээ, үнэлгээ, хариуцлага, суралцахуйн тогтолцоо Хнь одоо болон ирээдүйд хэрэгжих хөтөлбөрийг сайжруулах үүднээс нотолгоонд суурилсан шийдвэр гаргахын тулд байгууллага, хөтөлбөр, төслийн түвшинд холбогдох бүхий л мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг ашиглах гол зорилготой. ПИН-ийн Монгол дахь хөтөлбөрийн хувьд хяналт–шинжилгээ, үнэлгээ, хариуцлага, суралцахуйн алба нь суурийн төлөөлөгчийн удирдлагад үйл ажиллагаагаа явуулдаг. ПИН Монгол дахь хөтөлбөрийн хяналт – шинжилгээ, үнэлгээ, хариуцлага, суралцахуйн тогтолцоог харуулсан удирдамжийг бүрэн эхээр нь [эндээс үзнэ үү](#).



Alliance 2015
towards the eradication of poverty